ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ОРА-2022 /90/ НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас:70359826

Цахим хаяг:orkhon@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас:70355805

Цахим хаяг:erdeneb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Оргилмөрөн

Утас:70350757

Цахим хаяг:orgilmurung@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1. Аудитын санал дүгнэлт ..... 2

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл..... 4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 4

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 6

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан..... 6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 9

3. Аудитын тайлан ..... 11

3.1 Ерөнхий зүйл ..... 11

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт..... 11

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 12

3.4 Материаллаг байдал ..... 12

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 12

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 13

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг..... 14

3.8 Аудитын гол асуудал ..... 14

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 14

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт..... 14

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..... 15

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... 15

4. Аудитын илрүүлэлт..... 16

4.1 Залруулсан алдаа ..... 16

4.2 Төлбөрийн акт..... 16

4.3 Зөвлөмж ..... 16

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 18


### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ОНХО | Орон нутгийн хөрөнгө оруулалт |
| АЗД | Аймгийн Засаг дарга |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| АО | Ажил олгогч |

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 32

танай ____________-ны № ____________-т

ОРХОН АЙМГИЙН
ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТ НОГООН
БАЙГУУЛАМЖИЙН ГАЗРЫН
ДАРГА Х.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

**Аудитын санал дүгнэлт**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **39,154,604.00** | **38,686,244.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **39,154,604.00** | **38,686,244.00** |
| **351** | **Түүхий эд материал** | 38,281,204.00 | 37,812,844.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 38,281,204.00 | 37,812,844.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 873,400.00 | 873,400.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 873,400.00 | 873,400.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,603,348,604.73** | **1,576,245,991.17** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,603,348,604.73 | 1,576,245,991.17 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,152,583,604.73 | 1,520,175,991.17 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,122,067,103.00 | 1,528,681,180.11 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -53,197,312.09 | -77,377,526.25 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 138,578,000.00 | 138,578,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -71,277,268.99 | -81,218,239.64 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 39,232,637.00 | 31,956,137.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -32,268,917.06 | -28,194,012.00 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 20,546,110.00 | 20,546,110.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -11,096,747.13 | -12,795,658.05 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 5,836,400.00 | 5,836,400.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -5,836,400.00 | -5,836,400.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 450,765,000.00 | 56,070,000.00 |
| 39301 | Програм хангамж | 770,000.00 | 770,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -770,000.00 | -770,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 450,765,000.00 | 56,070,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,642,503,208.73** | **1,614,932,235.17** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,642,503,208.73** | **1,614,932,235.17** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,642,503,208.73 | 1,614,932,235.17 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 450,765,000.00 | 56,070,000.00 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | 450,765,000.00 | 56,070,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 599,891,369.42 | 973,594,608.39 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 599,891,369.4 | 606,470,581.95 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 367,124,026.44 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 591,846,839.31 | 585,267,626.78 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,642,503,208.73** | **1,614,932,235.17** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН ,(I)** | **490,011,950.00** | **850,491,771.77** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **94,292,950.00** | **409,675,271.77** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 94,292,950.00 | 409,675,271.77 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 94,292,950.00 | 0.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 94,292,950.00 | 0.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 409,675,271.77 |

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **395,719,000.00** | **440,816,500.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 25,000,000.00 | 65,350,200.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 25,000,000.00 | 65,308,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 42,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **370,719,000.00** | **375,466,300.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 370,719,000.00 | 375,466,300.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **460,018,016.02** | **447,829,835.56** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **460,018,016.02** | **447,829,835.56** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 451,215,255.81 | 433,086,851.56 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 281,471,676.79 | 268,128,145.00 |
| 210101 | Үндсэн цалин | 200,105,727.23 | 192,427,780.40 |
| 210102 | Нэмэгдэл | 58,061,753.76 | 55,679,511.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 23,304,195.80 | 20,020,853.60 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 35,638,437.00 | 34,517,419.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,370,978.00 | 24,032,826.41 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,896,424.00 | 2,672,696.99 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,313,573.00 | 2,138,156.89 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 574,627.00 | 515,794.61 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,482,835.00 | 5,157,944.10 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 5,270,900.00 | 4,918,846.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,301,327.00 | 1,078,227.00 |
| 210302 | Түлш, халаалт | 2,287,651.00 | 2,175,563.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,681,922.00 | 1,665,056.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 25,220,441.00 | 40,821,050.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,343,652.00 | 1,549,150.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 22,110,000.00 | 24,838,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,016,319.00 | 557,700.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 0.00 | 85,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 630,470.00 | 13,791,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 4,610,000.00 | 4,560,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,610,000.00 | 4,560,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 36,763,544.00 | 8,623,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 14,531,244.00 | 3,025,700.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,243,600.00 | 1,400,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 20,988,700.00 | 4,198,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 0.00 | 119,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 0.00 | 119,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 16,998,685.00 | 31,171,956.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,850,020.00 | 29,287,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,008,000.00 | 1,008,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 209,088.00 | 272,520.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 141,025.00 | 249,728.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 200,000.00 | 300,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,502,552.00 | 21,508.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 45,241,572.02 | 40,226,335.56 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 350,000.00 | 600,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 44,891,572.02 | 39,626,335.56 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **8,802,760.21** | **14,742,984.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,200,000.00 | 1,600,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,200,000.00 | 1,600,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 7,602,760.21 | 13,142,984.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,602,760.21 | 13,139,984.00 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 3,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **29,993,933.98** | **402,661,936.21** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 0.00 | 35,537,909.77 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 22,701,549.77 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | | 12,836,360.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 0.00 | -35,537,909.77 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **29,993,933.98** | **367,124,026.44** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **450,765,000.00** | **591,846,839.31** | **599,891,369.42** | **1,642,503,208.73** |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **450,765,000.00** | **591,846,839.31** | **599,891,369.42** | **1,642,503,208.73** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **450,765,000.00** | **591,846,839.31** | **599,891,369.42** | **1,642,503,208.73** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | -6,579,212.53 | 6,579,212.53 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | -394,695,000.00 | 0.00 | 0.00 | -394,695,000.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 367,124,026.44 | 367,124,026.44 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **56,070,000.00** | **585,267,626.78** | **973,594,608.39** | **1,614,932,235.17** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **395,719,000.00** | **440,816,500.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **395,719,000.00** | **440,816,500.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 25,000,000.00 | 65,350,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 25,000,000.00 | 65,308,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.00 | 42,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 370,719,000.00 | 375,466,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 370,719,000.00 | 375,466,300.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **390,079,000.00** | **420,571,500.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **390,079,000.00** | **420,571,500.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **381,276,239.79** | **405,828,516.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 281,471,676.79 | 268,128,145.00 |
| 210101 | Үндсэн цалин | 200,105,727.23 | 192,427,780.40 |
| 210102 | Нэмэгдэл | 58,061,753.76 | 55,679,511.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 23,304,195.80 | 20,020,853.60 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 35,638,437.00 | 34,517,419.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,370,978.00 | 24,032,826.41 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,896,424.00 | 2,672,696.99 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,313,573.00 | 2,138,156.89 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 574,627.00 | 515,794.61 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,482,835.00 | 5,157,944.10 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 5,270,900.00 | 4,918,846.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,301,327.00 | 1,078,227.00 |
| 210302 | Түлш, халаалт | 2,287,651.00 | 2,175,563.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,681,922.00 | 1,665,056.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 24,954,941.00 | 40,821,050.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,309,152.00 | 1,549,150.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 22,110,000.00 | 24,838,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,016,319.00 | 557,700.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 0.00 | 85,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 399,470.00 | 13,791,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 4,610,000.00 | 4,560,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,610,000.00 | 4,560,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,805,900.00 | 11,391,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,009,200.00 | 5,793,700.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,099,600.00 | 1,400,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,697,100.00 | 4,198,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 0.00 | 119,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 0.00 | 119,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 18,114,585.00 | 40,771,956.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 14,965,920.00 | 38,887,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,008,000.00 | 1,008,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 209,088.00 | 272,520.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 141,025.00 | 249,728.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 200,000.00 | 300,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,502,552.00 | 21,508.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 409,800.00 | 600,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 409,800.00 | 600,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **8,802,760.21** | **14,742,984.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,200,000.00 | 1,600,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,200,000.00 | 1,600,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 7,602,760.21 | 13,142,984.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,602,760.21 | 13,139,984.00 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 3,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **5,640,000.00** | **20,245,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **5,640,000.00** | **20,245,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **5,640,000.00** | **20,245,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 5,640,000.00 | 20,245,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 5,640,000.00 | 20,245,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-5,640,000.00** | **-20,245,000.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **0.00** | **0.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.00 | 0.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0.00 | 0.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 0.00 | 0.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **375,466,300.0** | **362,326,316.0** | **13,139,984.0** | **96.5%** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **375,466,300.0** | **362,326,316.0** | **13,139,984.0** | **96.5%** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **373,866,300.0** | **360,726,316.0** | **13,139,984.0** | **96.5%** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **275,049,700.0** | **268,128,145.0** | **6,921,555.0** | **97.5%** |
| 210101 | Үндсэн цалин | 188,782,600.0 | 192,427,780.4 | -3,645,180.4 | 101.9% |
| 210102 | Нэмэгдэл | 60,183,900.0 | 55,679,511.0 | 4,504,389.0 | 92.5% |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 26,083,200.0 | 20,020,853.6 | 6,062,346.4 | 76.8% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 37,131,700.0 | 34,517,419.0 | **2,614,281.0** | **93.0%** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,129,700.0 | 24,032,826.4 | 2,096,873.6 | 92.0% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,750,500.0 | 2,672,697.0 | 77,803.0 | 97.2% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,200,400.0 | 2,138,156.9 | 62,243.1 | 97.2% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 550,100.0 | 515,794.6 | 34,305.4 | 93.8% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,501,000.0 | 5,157,944.1 | 343,055.9 | 93.8% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 5,916,200.0 | 4,918,846.0 | **997,354.0** | **83.1%** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,545,500.0 | 1,078,227.0 | 467,273.0 | 69.8% |
| 210302 | Түлш, халаалт | 2,246,500.0 | 2,175,563.0 | 70,937.0 | 96.8% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,124,200.0 | 1,665,056.0 | 459,144.0 | 78.4% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 24,410,000.0 | 24,329,250.0 | **80,750.0** | **99.7%** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,310,000.0 | 1,507,150.0 | -197,150.0 | 115.0% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,300,000.00 | 20,300,000.00 | 0.00 | 100.0% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,020,000.0 | 557,700.0 | 462,300.0 | 54.7% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210404 | Ном, хэвлэл | 300,000.0 | 85,000.0 | 215,000.0 | 28.3% |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 80,000.0 | 0.0 | 80,000.0 | 0.0% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,400,000.0 | 1,879,400.0 | -479,400.0 | 134.2% |
| **2105** | **Нормативт зардал** | 4,560,000.0 | 4,560,000.0 | 0.0 | 100.0% |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,560,000.0 | 4,560,000.0 | 0.0 | 100.0% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,864,400.0 | 9,861,900.0 | **2,500.0** | **100.0%** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,264,400.00 | 4,263,700.00 | 700.00 | 100.0% |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,400,000.00 | 1,400,000.00 | 0.00 | 100.0% |
| 210604 | Урсгал засвар | 4,200,000.0 | 4,198,200.0 | 1,800.0 | 100.0% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 858,500.0 | 119,200.0 | **739,300.0** | **13.9%** |
| 210702 | Дотоод албан томилолт | 858,500.0 | 119,200.0 | 739,300.0 | 13.9% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 15,475,800.0 | 13,691,556.0 | **1,784,244.0** | **88.5%** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,806,800.00 | 11,806,800.00 | 0.00 | 100.0% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,008,000.0 | 1,008,000.0 | 0.0 | 100.0% |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 340,000.00 | 272,520.00 | 67,480.00 | 80.2% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 250,000.00 | 249,728.00 | 272.00 | 99.9% |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 171,000.00 | 33,000.00 | 138,000.00 | 19.3% |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 300,000.00 | 300,000.00 | 0.00 | 100.0% |
| 210807 | Газрын төлбөр | 1,600,000.00 | 21,508.00 | 1,578,492.00 | 1.3% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 600,000.0 | 600,000.0 | **0.0** | **100.0%** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 600,000.0 | 600,000.0 | 0.0 | 100.0% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,600,000.0 | 1,600,000.0 | 0.0 | 100.0% |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,600,000.0 | 1,600,000.0 | 0.0 | 100.0% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,600,000.0 | 1,600,000.0 | 0.0 | 100.0% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **375,466,300.0** | **362,326,316.0** | **13,139,984.0** | **96.5%** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 375,466,300.0 | 362,326,316.0 | 13,139,984.0 | 96.5% |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 375,466,300.0 | 362,326,316.0 | 13,139,984.0 | 96.5% |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 26.0 | 26.0 | **0.0** | **100.0%** |
| 620001 | Удирдах ажилтан | 1.0 | 1.0 | 0.0 | 100.0% |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 4.0 | 4.0 | 0.0 | 100.0% |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 21.0 | 21.0 | 0.0 | 100.0% |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **26.0** | **26.0** | **0.0** | **100.0%** |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 26.0 | 26.0 | 0.0 | 100.0% |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **24,818,869.00** | **65,347,200.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **24,818,869.00** | **65,347,200.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 24,818,869.00 | 65,347,200.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 17,687,751.00 | 0.00 |
| 210101 | Үндсэн цалин | 16,498,351.00 | 0.00 |
| 210102 | Нэмэгдэл | 1,189,400.00 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 2,135,440.00 | 0.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,519,419.00 | |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 178,754.00 | |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 142,998.00 | |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 35,757.00 | |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 258,512.00 | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 195,678.00 | 0.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 195,678.00 | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,220,000.00 | 16,491,800.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 0.00 | 42,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,000,000.00 | 4,538,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 70,000.00 | 0.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 150,000.00 | 11,911,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 450,000.00 | 0.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 450,000.00 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,130,000.00 | 1,530,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,030,000.00 | 1,530,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 100,000.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 0.00 | 47,325,400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0.00 | 47,325,400.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **25,000,000.00** | **65,347,200.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **25,000,000.00** | **65,347,200.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 25,000,000.00 | 65,305,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.00 | 42,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **0.00** | **0.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бүртгэл санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Оргилмөрөн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

“Цэцэрлэгжүүлэлт - Ногоон байгууламж” орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь Монгол улсын Ойн тухай хууль, Байгаль орчны тухай хуульд заасан чиг үүргийн дагуу хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчлан хамгаалах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх нэгдсэн бодлогыг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, үүрэг бүхий өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, төрийн үйлчилгээ үзүүлэх ажлыг эрхлэх орон нутгийн төсөвт үйлдвэрийн газар мөн.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ТБОНӨХБАҮХАТхууль зэрэгт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийн нийт зардал ба цэвэр зээлийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл **дунд** гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 375,466.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,754.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,628.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 27,571.0 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар буурсан байна. Нийт хөрөнгийн бууралт нь тайлант оны бараа материал, үндсэн хөрөнгийн бууралттай холбоотой байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.0 |
| Авлага | 0.0 | 0.0 | 0.0 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 39,154.6 | 38,686.2 | -468.4 |
| Үндсэн хөрөнгө | 1,603,348.6 | 1,576,246.0 | -27,102.6 |
| **Нийт хөрөнгө** | **1,642,503,2** | **1,614,932.2** | **-27,571.0** |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,642,503,2 | 1,614,932.2 | -27,571.0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,642,503,2** | **1,614,932.2** | **-27,571.0** |

Мөнгөн хөрөнгө болон авлага, өр төлбөрийн данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 38,686.2 мянган төгрөг болж 468.4 мянган төгрөгөөр буурсан байна. Газрын даргын тушаалаар оны эцэст тооллогын комисс болон өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн 12,836.4 мянган төгрөгийн бараа материал акталж данс бүртгэлээс хассан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,614,932.2 мянган төгрөг болж 27,571.0 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 20,245.0 мянган төгрөгийн мод, бут, сөөг шинээр худалдан авсан, ОНХО-аар нийлүүлсэн нийт 409,675.3 мянган төгрөгийн модыг үнэ төлбөргүй хүлээн авс үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн хэдий ч элэгдлийн зардал 39,626.3 мянган төгрөг, АЗД-ын 2021 оны А/165 болон А/719 дүгээр захирамжаар 30,582.7 мянган төгрөгийн өртөгтэй, 7,881.1 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг акталж, мөн АЗД-ын 2021 оны А/38 дугаар захирамжаар биет бус хөрөнгөд бүртгэлтэй 18,795 м2, 394,695.0 мянган төгрөгийн үнэлгээтэй мод үржүүлгийн газрыг тус тус данснаас хассан тул үндсэн хөрөнгийн данс буурсан байна.

Мөн АЗД-ын 2021 оны А/149 дүгээр захирамжаар тус байгууллагад бүртгэлтэй Hyundai Porter маркийн /10-74орх, 1084 орх/ автомашинуудын ашиглалтын хугацаа дуусаж актлах шийдвэр гарсан боловч, үнэ тогтоон дуудлага худалдаагаар худалдаагүй байгаа тул данс бүртгэлээс хасаагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 27,571.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 367,124.0 мянган төгрөг хэдий ч тус байгууллагын бүртгэлээс 394,695.0 мянган төгрөгийн эзэмшил газрыг хассанаас шалтгаалжээ.

Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 360,479.8 мянган төгрөгөөр буюу 73.6 хувиар өссөн байна. Өмнөх оноос орлого өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоос /ОНХО-аар нийлүүлсэн мод, суулгац, зүлэгжүүлсэн талбай/ шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 12,188.2 мянган төгрөгөөр буюу 2.6 хувиар буурсан байна. Энэ нь цалин, НДШ-ийн зардлын бууралттай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын ирүүлсэн төсвийн төсөл, өмнөх онуудын төсвийн гүйцэтгэлд үндэслэн төсвийн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн 375,466.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлж, нийт зарлагыг 375,466.3 мянган төгрөгөөр тооцон баталж төсөвлөсөн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71502 /Хот байгуулалт, тохижилт/ хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 375,466.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 362,326.3 мянган төгрөгийг зарцуулж 13,140.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 362,326.3 мянган төгрөг буюу 96.5 хувьтай байгаа нь цалин, НДШ-ын зардлыг 9,535.8 мянган төгрөгөөр байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 997.4 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 739.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1,784.2 мянган төгрөгөөр тус тус дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансны 65,350.2 мянган төгрөгийн гүйлгээ тайлагнасан байна. Хотын нийтийн эзэмшлийн гудамж талбайд арчилгаа тордолт хийх 52,400.2 мянган төгрөг, Ковид-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, байгууллагын үйл ажиллагаанд халдвар хамгааллын дэглэм сахиулах, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл бүрдүүлэх зорилгоор АЗД-ын 2021 оны А/494 дүгээр захирамжаар 12,908.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт тус тус олгосон байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 талбарын мэдээллийг бүрэн хугацаанд нь оруулсан байна. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 10,320.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ, зарлагын 32,540.0 мянган төгрөгийн 3 гүйлгээг дутуу байршуулсан, 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын 22,626.7 мянган төгрөгийн 2 мэдээллийг алдаатай мэдээлсэн байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 73.5 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 1 зөвлөмжийн биелэлт хангагдсан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй ба дараагийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн дансыг авч үзэж болох юм.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 466,627.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 465,790.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 187.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 719.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан 42.0 мянган төгрөгийн орлогын ангилал, нэмэлт данснаас төвлөрүүлсэн 3.0 мянган төгрөгийн зардлын ангилал, мөн санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан 409,675.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн орлогын ангиллыг тус тус алдаатай илэрхийлсэн байна.
- Санхүүгийн тайланд биет бус хөрөнгөөр бүртгэлтэй газрын үнэлгээний 56,070.0 мянган төгрөгийг санхүүгийн байдлын тайлангийн эзний өмчийн хэсэгт засгийн газрын сангаар тайлагнасан байна. Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал"-ын 5.5-д газрыг засгийн газрын сангийн эзэмшигчийн өмчийн бусад хэсэгт тайлагнахаар тусгагдсан болно.

### 4.2 Төлбөрийн акт

1. Байгууллагын дарга эрх бүхий этгээдийн холбогдох шийдвэргүйгээр 2021.01-р сард 187,031 төгрөгийн ур чадварын нэмэгдэл бодож авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 2-д “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч шийдвэрлэнэ” гэсэн заалттай нийцэхгүй, хэмжилт болон үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u>Төлбөрийн акт тогтоов

### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Зардлын данстай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Бодогдсон цалин болон үр дүнгийн тайлангаарх цалингийн зардал 383.4 мянган төгрөгийн зөрүүтэй, цалингийн зардлын журналын бичилтийг цалин олгосон, ндш, ххоат болон бусад суутгал төлсөн төлбөрийн дүнгээр зардал өглөг үүсгэж хаалтын бичилт хийж гүйцэтгэж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 3.6 дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

*1.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

Бодогдсон цалингийн дүнгээр цалингийн зардал бүртгэж, цалингийн зардал, суутгалтай холбоотой НББ-ын журналын бичилтийг үнэн зөв хийх.

***2. Зардлын данстай холбоотой асуудал***

*2.1. Илрүүлэлт:*

Тайлант оны жилийн дүнгээр цалингийн зардлаас АО-с төлөх НДШ-ийн зардалд 336.4 мянган төгрөг гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудтай нийцэхгүй, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.1.6-д “Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

*2.2. Өгсөн зөвлөмж:*

Дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр цалин, АО-с төлөх НДШ-ийн зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй байх.

### ***3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

*3.1. Илрүүлэлт:*

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 талбарын мэдээллийг бүрэн хугацаанд нь оруулсан хэдий ч цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 10,320.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ, зарлагын 32,540.0 мянган төгрөгийн 3 гүйлгээг дутуу байршуулсан, 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын 22,626.7 мянган төгрөгийн 2 мэдээллийг алдаатай мэдээлсэн байна..

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-тай тус тус нийцэхгүй байна.

*3.2. Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, цахим хуудаст мэдээлэх мэдээллийг бүрэн гүйцэт мэдээлж, дотоод хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | Орхон аймгийн ЦНБГ | 1 | 383.4 | | | | | | | 1 | 383.4 |
| 2 | Орхон аймгийн ЦНБГ | 1 | 336.4 | | | | | | | 1 | 336.4 |
| 3 | Орхон аймгийн ЦНБГ | 1 | 187.0 | | | 1 | 187.0 | | | | |
| 4 | Орхон аймгийн ЦНБГ | 1 | 0.0 | | | | | | | 1 | 0.0 |
| 5 | Орхон аймгийн ЦНБГ | 1 | 409,720.3 | 1 | 409,720.3 | | | | | | |
| 6 | Орхон аймгийн ЦНБГ | 1 | 56,070.0 | 1 | 56,070.0 | | | | | | |
| **Дүн** | | **6** | **466,697.1** | **2** | **465,790.3** | **1** | **187.0** | **0** | **0.0** | **3** | **719.8** |